

## 1

**МЭРГЭЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА БА СЭТГЭЛГЭЭНИЙ ХУВЬСАЛ**

Т.Жааваа, Б.Хүрэлбаатар

Эдүгээ үндэсний төдийгүй олон улсад дуу хоолой өргөх судалгааны нэн сонирхолтой сэдэв ба сайжруулалт, ээдрээтэй зүйлс нилээд байна. Бид энд мэргэжлийн хувьслын зураглал, сэтгэлгээний парадигмийг өөрчлөх чиг хандлага, тулгуур асуудлыг дэлгэхийг хичээлээ. Экономикс, түүний дотор нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн үйлчилгээ нь чухамдаа хэмжил зүйн ухаан мөн.

Бидний үндсэн судлагдахуун, хэмжлийн объект бол мөнхийн хувьсалд буй үнэ цэнэ юм. Эдгээр үнэ цэнэ бидний орчин тойронд байнга орших ба их мэдрэмтгий индикатораар асар хурдтай хэмжин өгөгдлийн сан үүсгэж, улмаар макро ба микро орчныг хөтлөх санхүүгийн болон удирдлагын хэрэглүүр болгож хувиргах нь орчин үеийн мэдээллийн технологи, мэргэжлийн хувьслын гол судлагдахуун болж байна.

*Гэхдээ эдийн засгийн үнэ цэнэ* – сэтгэлгээний их төвөгтэй ойлголт, математикийн далд утгатай нууцгай хэмжигдэхүүн юм. *Туйлын ярвигтай нь алив биет, биегүй зүйлсийг дагаж оршин буй хэмжлийн объект - эдийн засгийн үнэ цэнэ мөнхийн хувьсал, хөдөлгөөн хийж*, хормын зуур өөр утга (параметр) авч эхэлдэгт оршино. Нөгөө талаас, хязгааргүй хэмжээст асар том биет, зах хязгааргүй ертөнц бөгөөд хүн төрөлхтөн бүрэн гадаргуйг хэзээ ч барьж чадахгүй гэсэн логик дүгнэлт гарч байна. Экономикс, түүний онол, практик аль болох төгс хэмжихийн төлөө буй ч орчин цагийн бүдүүн хэмжлийн систем, мэдлэгийн хуримтлал маш өчүүхэн хэсгийг хэмжиж байна. ХХI зууны мэдээллийн хувьсгал, бичил (нано) технологи ба санхүүгийн бичил нэгжийн парадигм ч тус болохгүй, цаана нь асар том ертөнц үелэн гарч ирэх болно.

Төвөөс зугатах хүчний үйлчлэлд оршдог, их урсамтгай шингэн биет ч гэж төсөөлж болно. Хөрөнгө, хариуцлага, зүйлсийг дагаж орших урсамтгай биетийг их мэдрэмтгий хэмжлийн индикаторуудаар дамжуулж өргөн талбайгаар барьж авахгүй л бол төвөөс зугатах хүчний нөлөөгөөр эргэлтээс үүрд гадагшлаж, бүтээмжийг унагах ба сөрөг (гадагш) урсгалын хүлээлтүүд эсрэг биетэд шилжиж, өрсөлдөгчийн халаасыг зузаатгана.

Хэмжлийн динамик тавилт индикаторыг илүү төгсжүүлсэн пүүс компани, улс гүрэн, бүс нутагт бизнес төвлөрч, мөнгөний гадагш урсгал хумигдан, эдийн засгийн үнэ цэнэ бүрэн дүүрэн өөрт шингэж, өгөөжөө өгөх нь нууц биш. Энэ урсамтгай шинж чухамдаа бизнес иргэншлийн хүчний харьцаа, өрсөлдөөний хувь заяаг шийдэж ирсэн.

“Их нүүдэл” гэгч 7000 жилээс эхтэй иргэншлийн урсгал Африкаас Европ, Төв Азиас Ойрхи Дорнод, Еврази, Америк, Өмнөт хятадаас Зүүн Өмнөт Ази, Авсрали руу чиглэсэн ХҮ зуунаас эсрэг урсгалд орж, ХХ зууны төгсгөлөөс үндсэн чиглэлд эргээд орсон. Товчдоо дорно зүгээс (африк, төв ази, ойрхи дорнод) Европ (ХҮ-ХІХ), Америк (ХІХ-ХХ), Азид (ХХІ) эрэмбэ дараатай шилжсэн их гольдрол, хүчний тэнцвэр ба байршлууд (координат) үүнийг нотлож өгсөн. Бидний төсөөлж буй ХХІ зууны мэргэжлийн хувьслын зураглал:

**Нэгд, Мэргэжлийн үйлчилгээний үндсэн хөтлөгчид мэдээллийн технологи, орчны хувьсал ба даяаршлын хүч, хүний нөөц, мэдлэгийн менежмент, хэмжлийн ухааны шинэ урсгал гэсэн нижгээд улсын мэргэжлийн холбоодын үзэлтэй санал нэгдэж байна. (См: Австралийн Мэргэжсэн Нягтлан Бодогчдын Институт, “Мэргэжлийн хөтөлбөр - 2020” хувилбар, 1998).**

**Хоёрт, Мэдээллийн технологи - мэргэжлийн хувьслын гол хөтлөгч. Өнөөдөр он-лайн сүлжээ, е-худалдаа жирийн хэрэглээ болж, алив хэлцэл, төлбөр, солилцоо цахим карт, интернет сүлжээгээр хийгдэн, огт мэдэхгүй талууд үйлдэхүүнээ веб сайтаар санал болгож эхлэв. Мэдээллийн задгай (кибер) орчны эрсдэл, хамгаалалтын горим ба бэлтгэгчийн ёс зүйг хөгжүүлэх нь судалгаа хөгжлийн төвөгтэй сэдэв байх болно. Hacker'-уудтай тэмцэж, Anti Virus, Cookies хамгаалалтын техник, Web Trust, World Wide Web сүлжээний нууцлал, хамгаалалт, хяналтын горимыг бүтээх ч шаардлага байна.**

**Гуравт, Даяаршлын эрч хүч, өрсөлдөөн, орчны хувьсал, хүний нөөц, мэдлэгийн менежмент дэвшил - мэргэжлийн хувьслын гол өдөөгч байх болно. Даяаршлын үндсэн шинж: нэгдсэн мөнгөн тэмдэгт ба хэл, ёс зүй, е-худалдаа, санхүүгийн зуучийн үйлчилгээ гэж үзлээ. Мэдлэгийн менежмент дэвшил – хүний нөөцийн хэмжлийн мэдрэмтгий индикаторууд үүссэнээр санхүүгийн тайлагнал дэхь эдийн засгийн үнэ цэнэ, орлого, ашгийн хэмжил, бизнес үнэлгээ ихээхэн төгсжинө.**

**Дөрөвт, татвар, хууль, соёл, ёс зүйн хэв шинж – мэргэжлийн хувьсалд хүчтэй нөлөөтэй хүрээлэн буй орчны хувьсагч даруй мөн. Байршил, оношлогооны олон хөтлөгч бүхий судалгааны загварыг Геерт Хофстид \1980\, С.Ж Грей \1988\ нар үндэслэжээ. Ёс зүйг Геерт Хофстид, соёлын нөлөөг С.Ж Грей их далайцтай хөнджээ. СЖ Грей мэргэжлийн төлөвшилд соёлын хувьсагч хүчтэй нөлөөтэйг нотолж, хэвшсэн ёс зүйн хэв шинж (IC), нийгмийн хувьсагчийг (SV) хөндсөн Хофстидийн загвар ба бүртгэлийн систем (AS), мэдээллийн хувьсагчийн (AV) логик уялдааг таамаглаж баталсан.**

**Тэд мэргэжлийн чадавх \Professionalism\, нэг хэв загварын хандлага \Uniformity\, хуучинсаг үзэл \Conservatism\, нууцлаг шинж \Secrecy\ гэсэн 4 шинжээр үндэсний бүртгэлийн соёлд үнэлэмж өгөх тухай сонирхолтой**

*санааг сэдэжээ.* Дурдсан шинжүүд бүс нутгийн загвар, үндэсний мэдээллийн зохицлыг тэнцвэржүүлэх нөлөөтэй учир туршилтын загварыг өргөжүүлэх шаардлага мэргэжлийн холбоодод тавигдаж байна.

**Тавд, Мэргэжлийн судлагдахууны томъёололд семантик \агуулга, хэлбэр\, прагматик \өгөөж, хэрэглээ\, синтаксик \ бүтэц, байгууламж\ гэсэн 3 хэмжээст хамаарлын координат заавал үүснэ. Мэдээллийн татвар, иргэний эрх, ёс зүйн хэв шинж төдийгүй хэрэглэгчийн зан үйл, сэтгэл зүйг хөндсөн сэтгэлгээний персоналист, бихевиорист чиг урсгал ба хамаарлыг судлах нь чухалд тавигдана.**

**Мэдээллийн технологи, орчны өөрчлөлт, мэргэжлийн хувьслын чиг хандлагаас үзвэл судлагдахууны синтаксик чиглэл, бихевиоризм ба персонализмыг түлхүү хөгжүүлэх нь зайлшгүй болсон. Хэрэглээний үүднээс алив мэдээлэл удирдлагын шийд гаргагч бүлгүүдийн зан үйл, сэтгэл зүй, үйл хөдлөлийг залж, тэдний зүгээс хийх харну үйлдлийн өдөөгч байх учиртай. (Eldon S. Hendriksen, Michael F. Van Breda Accounting theory)**

**Зургаа, Мэргэжлийн холбоодын хэв шинж ба улс гүрэн, бүс нутгуудын макро орчны нөлөөг загварчлах зайлшгүй шаардлага бий. Нягтлан Бодогчдын Олон Улсын Холбоо (НБОУХ)-ны дэлхийн 28 улс гүрний хууль, эдийн засаг, соёлын нөлөөг хөтлөгч хувьсагчаар дуудаж, мэргэжлийн (байгууллага) холбоодын үндэсний хэв шинжийг загварчилсан судалгааны туршилтын загвар их сонирхол татдаг. Гэхдээ хос тавилт 3 хувьсагчтай туршилтын загварыг олон хувьсагч оруулж сайжруулах, тухайлбал нижгээд олон эрэмбийн хөтлөгч бүхий 4-5 хувьсагч болгож өргөтгөх боломжтой гэж үзсэн. (Соёлын хувьсагчийг алсын зайн нөлөөтэй ба нөлөөгүй; эрх зүйн хувьсагчийг иргэний ба нийгмийн хуультай; эдийн засгийн хувьсагчийг аж үйлдвэржсэн ба шилжилтийн гээд хууль, эдийн засгийн хувьсагчууд хоорондоо хамааралгүй, харин соёлын хувьсагч хууль, эдийн засгийн хувьсагчид хүчтэй нөлөөтэй гэсэн тавил өгчээ).**

Энэ шалгуураар монгол нүүдлийн соёл иргэншилт, алсын зайн нөлөөгүй, иргэний хуультай, эрчимжээгүй бага оворын хөгжлийн эдийн засагтай улс гүрний бүлэгт багтаж байна. Хөгжлийн ийм зурваст төрийн зохицуулалт чухал бөгөөд цаашид олон нийт (төрийн бус), хувийн хэвшилд аажмаар шилжих нь илүү нийцтэй гэж үзсэн.

Эцэст нь санхүүгийн 2 (Accounting Profit - AP, Economic Profit -EP) индикаторыг шинээр томъёолж, хэмжлийн (экономикс) ухааны төв тэнхлэгт байршуулж, орчин цагийн хэвшсэн (прагматик) сэтгэлгээг өөрчлөх сэдлийг дэвшүүлж, далайцтай оролдлого хийх цаг мөчид бид тулжээ. Сэдвийг даацтай хөндөхөд олон улсын санхүүгийн дэмжлэг хүсч, найдвартай эх сурвалж ба олон улсын түнш хайж байна.

Эхлээд прагматик сэтгэлгээг AP индикаторт уяж өгье. Аудитлагдсан нийт орлого (Total Revenue -TR), нийт зардлын (Total Cost -TC) зөрүүгээр татварын ашгийн (AP) индикатор үүсэх бөгөөд макро эдийн засгийн үндэсний тооцооны систем, татварын тогтолцоог бүхэлд дэмжинэ. Цаашид нэмэгдсэн өртгийн парадигм үүсэхийг ч үгүйсгэх аргагүй.

Түүхэн өртөг (Historical Cost - HC) – эд зүйлс хэмжилд өртөх агшны үнэ цэнэ. Хэмжилтүүд өнөөгийн үнэ цэнэ (Present Value - PV), одоогийн өртөг (Current Cost - CC), зах зээлийн үнэ (Selling Price - SP), өнөөгийн цэвэр үнэ цэнэ (Net Present Value - NPV), өмчийн үнэ бүрдлийн (Capital Assets Pricing Model - CAPM) загвар гээд хамгийн мэдрэмтгий индикаторт суурилдаг ч хормын зуур хувьсаж, өөр утга авдаг учир бүхэлдээ тогтмол үнийн хэмжээст өгөгдлийн сангийн царцанги сүлжээ үүсдэг.

AP индикаторт өртсөй (барьж авсан) үнэ цэнэ, мөнгөн урсгалын хүлээлтүүд том (макро) биетийг жолоодоход хангалттай бөгөөд хүрэлцээтэй нөхцөл болдог. Дж.Кейнсийн төрийн зохицуулалт, М.Фридман, П.Самуэльсон, Ж.Хикс, Р.Манделлын мөнгө ба сангийн бодлого, эдийн засгийн мөчлөгийн сонгодог онол, нээлтүүд AP индикаторт суурилсан нь санамсаргүй зүйл биш.

Эрт дээр үеэс санхүүгийн баримтыг шавар, чулуу, яс, мод, муутуу (*papyrus*) зэрэгт элдэв код, тэмдэгтээр сийлж эхэлсэн нь хэмжлийн AP индикатор ба мэдээллийн технологийн анхны үр хөврөл байв. Энд нүүдэлчдийн иргэншил, түүний дотор монголчуудын оруулсан хувь нэмэр асар их билээ. “Хүннүчүүд яс сийлж, модоор ороон олон түшмэл тэмдэглэлцэх бөгөөд эзэн, түшмэд, дээд, доорд хэрэглэнэ” гэж хятад сурвалжид өгүүлсэн нь буй. (*Хуань Куань. Давс, төмөрийн тухай бодрол, Шанхай, 1958, 376 тал*)

Эртний түүхэн, *кюнейформ дүрст* энгийн бичилтийн гарвал үүслийг 5000 – 10000 жил гэж нийтээр нэгэнт баримжаалж хэвшсэн. Гэхдээ олон хадны бичээс дэхь элдэв цэг толбо, ац, хэрээс, тууш зураас, бүтэн ба хагас дугуй, гурвалжин, дөрвөлжин, амьтны мөр, сам шүд, алхан хээ дардац зэрэг код ба дүрс тэмдэгтүүд эртний санхүүгийн хэмжлийн (данс бичилт) ул мөр гэлтэй. Монгол хадны бичээс дэхь энгийн бичилтийн археологи цаг тооны энэхүү буурал хуудсыг доор хаяж 10000 - 15000 жилээр урагшлуулж болзошгүй юм.

Хэмжлийн AP индикаторын суурь XV зуунд үүсч, өнөөдрийг хүртэл улс гүрэн, бүс нутгийн ялгаатай загвар болтлоо хөгжлийн ээдрээтэй, урт удаан замыг туулжээ. *Англи-сагсон* их эртний үндэстэн дамнасан (олон улсын) загвар бөгөөд үнэт цаас, санхүүгийн зах зээлийн тусгал болж үүссэн. Олон улсын (НБОУХ, НББОУСХ, НБОУХУСХ) хамтын чармайлтын дүнд СТОУС, УСНББОУТ (2 тунхаг, 35 стандарт, 30 тайлбар) хэвлэсэн нь *улс гүрний үндэсний тооцооны систем, татварын тогтолцооны суурь параметруудийн гаргалгааг ижилсүүлэхэд чиглэсэн.*

AP өдөөгч СТОУС, УСНББОУТ-ыг үндэсний хүрээнд шууд хэрэглэх, үндэсний стандартаар баяжуулах, үндэсний онцлогыг тодруулах, нэмэлт тайлбар тодотгол хийх, зарим стандартыг тайлбарлах, стандарт бүрийг үндэсний хүрээнд тодруулах гэсэн даяаршилд нэгдэж, хариу үйлдэл хийх боломжит хувилбар ба сонголтуудтай зах зээл төлөвшиж буй улс гүрнүүд тулж ирсэн.

Монголд AP индикатор шинэтгэлийн гараа амжилттай эхэлж, зах зээл төлөвшиж буй улс орнуудын дотор бид нилээд урагш ахиж чадсан. Гэхдээ дэлхийн жишигт хүрсэн үндэсний нягтлан бодох бүртгэл, аудитын

тогтолцоо бүрдээгүй, мэдээллийн шинэтгэл, мэргэжлийн бодлого, хяналтын бүтэц, байгууламжууд дөнгөж эхлэл төдий байна.

Монгол СТОУС, УСНББОУТ-ыг хуулбарлан нэгдэж, AP индикатор дэмжих сонголт хийсэн нь хөгжлийн ялгаа, үндэсний хэв шинж, зах зээлийн бүтцийн онцлог, банк санхүүгийн зах зээлийн уламжлал зэрэг олон шалтгааны улмаас тохирохгүй зүйл их, хараахан төлөвшөөгүй харилцааг ч хөндөх нь бий.

Бидний хувьд гадны бэлэн загварыг шууд хуулбарлан хэрэглэж даяаршилд нэгдсэн Кипр, Кувейт, Латви, Пакистан, Тринидад, Тобаго, Хорват биш, харин стандарт нэг бүрийг үндэсний хэмжээнд жишиж тодруулах сонголт хийж, AP хэмжилтийг төгсжүүлсэн Австрали, Гонконг, Дани, Итали, Шинэ Зеланд, Швед, Югославын туршлага ба сонголтууд илүү сонин бөгөөд нийцтэй байгаа юм.

Гэхдээ Бичил (микро) орчин, тухайлбал бизнес ертөнц дэхь хүчний харьцаа, өрсөлдөөний хувь заяаг өөрчлөхөд илүү их мэдрэмтгий EP индикатор хэрэгтэй. Индикатор хэрхэн үүсэх вэ. Хөрөнгө, үүрэг хариуцлага мэт алив биет, биегүй зүйлсийн үнэ цэнийг амьдралын мөчлөгөөр нь зураглавал уг индикатор - эдийн засгийн ашгийн EP тэнхлэг үүснэ. Үндсэн тавил шийдэл нь микро экономикс дэхь хэвшсэн прагматик урсгал ба сэтгэлгээг дараах байдлаар сайжруулахыг шаардсан.

Энд EP - индикатор багцууд татварын ашгийн (AP) индикатор, аудитлагдсан нийт орлого (Total Revenue - TR), санхүүгийн нийт зардал (Total Cost - TC), эдийн засгийн (Economic expence - EE) болон ялгаварт зардал (Differential Cost -DC), орхигдсон боломж өртгийн (Opportunity Cost -OC) хэвшмэл ухагдахуунтай хэрхэн холбогдох вэ гэсэн сонирхолтой асуудлууд үүснэ.

AP индикатор EP - мөчлөгийн зөвхөн нэг үе шатыг хэмжихэд чиглэжээ. Аудитлагдсан нийт орлого (TR), санхүүгийн нийт зардал (TC) нь уг мөчлөг дэхь үе шатны санхүүгийн баримтаар нотлогдсон багцууд аж. Энд хувьсах ба тогтмол төлөв ( $TC = VC + FC$ ), хамааралтай ба хамааралгүй ( $TC = RC + IC$ ) багцууд EP – индикаторыг дэмжих учиртай.

Харин экономикс, менежментийн ухаанд эдийн засгийн зардлын (EC) багц амьдралын мөчлөг дэхь орцуудыг хувиргах үе шатны хамааралтай зардлын багц (RC) ба орхигдсон боломж өртгийн (OC) нийлбэртэй тэнцүү ( $EC = RC + OC$ ) гэсэн томъёолол их хэвшмэл тархсан. Бид эдүгээ өргөн тархаж буй төгс ахиуц орлогын (ТАО) ойлголтыг EP – индикатор гэж үзэж буй. Харин EP – индикаторын хувьд мөчлөгийн (AMЗ), эдийн засгийн болон ялгаварт зардлын багцууд ижил утгатай гэсэн таамаг дэвшүүлсэн.

Эцэст нь, бичил (микро) орчинд *нэгд*, шугаман үйлдэл (үйл явц), зардлын урсгал, эдийн засгийг инженерчлэх, *хоёрт*, маркетингийн төгс (мэдээллийн) сүлжээг үүсгэх явдал EP хэмжил ба индикаторыг төгсжүүлэх нөхцөл гэж үзлээ. Ялангуяа мөчлөг дэхь орхигдсон боломжийн үнэ цэнийг өргөн багтаамжаар барьж авахад маркетингийн мэдээллийн төгс сан ба сүлжээ чухал юм.

Экономикс татварын ашгийг их сонирхдог ч олон хувилбараас сонголт хийж, шийдвэр гаргахдаа их мэдрэмтгий ахиуц, эдийн засгийн

ашгийн (EP) индикаторыг төв тэнхлэгт тавих учиртай. Дурын цагт AP – суурийг зах зээл, сегменчлэл, маркетингийн мэдээллийн арвин баялаг сантай харьцаж EP индикаторт асар хурдтай хувирган, илүү мэдрэмтгий жолоодлогын параметруудийг үүсгэх учиртай.

General Motors, General Electric, аль эсвэл Matsushita, Mitsui одоо хир салбартаа тэргүүлэгч байгаагийн нууц нь техник, хүмүүн капиталын давуу урсгалд бус төгс санхүүгийн хэмжил бүхий EP индикатораар урсамтгай биетийг илүү талбайтай барьж өөртөө шингээн, гадагш мөнгөн урсгалын хүлээлтүүдийг хаасанд оршдог.

Монголд маркетингийн чиг урсгал, өрсөлдөөний хувилбарт үйлдэлд нийцсэн хөдөлгөөнт (EP) индикаторын динамик загвар хөгжөөгүй, тавилыг нь эзэмшсэн үндэсний менежер хомс, тэгээд ч засгийн газар, пүүс компани гадны менежер хөлслөх болсон. Мэдээллийн хэрэглээний чиг, сайжруулсан өгөгдлийн сан, мэдрэмтгий EP индикатор огт сонирхохгүй явж ирсэн.

Менежерүүд тогтмол үнийн (AP) индикатораар сонголт хийж, шийдвэр гаргаж байгаад хэргийн учир оршиж байна. Үр дагавар - мөнгөн урсгал гадагшлаж, эдийн засгийн үнэ цэнийг өөртөө шингээх чадваргүй болсонд оршино. Өнөөдөр үндэсний эргэлтээс хором /секунд/ тутам хэдэн сая доллар тасралтгүй гадагшлан, өрсөлдөгчийн халаасыг зузаатгаж буйд гол хэргийн учир оршиж байна.